



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Судалгааны тэргүүлэх болон үндсэн чиглэл, түүнд хамаарах голлох
судалгааны сэдвийг тогтоох тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.11-р зүйл, "ШУТИС-ийн дүрэм"-ийн 4.5;
4.6.1 дэх заалтууд, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 3.2.2, 7.3 дахь заалтууд, Эрдмийн
зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн судалгааны тэргүүлэх болон үндсэн чиглэл, үндсэн чиглэлийн
хүрээний голлох судалгааны сэдвийг Эрдмийн зөвлөлийн гишүүдийн саналыг
нэмж тусгаж батлуулахыг дэмжсүгэй.
2. Батлагдсан судалгааны тэргүүлэх болон үндсэн чиглэл, үндсэн чиглэлийн
хүрээний голлох судалгааны сэдвийг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс
эхлэн мөрдсүгэй.
3. ШУТИС-ийн судалгааны тэргүүлэх болон үндсэн чиглэлийг 5 жил тутамд,
судалгааны үндсэн чиглэлийн хүрээний голлох судалгааны сэдвийн жагсаалтыг
3 жил тутамд шинэчлэн баталж байхаар тогтоосугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.НАМНАН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210001



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Эндаументын сангийн журмыг дэмжих тухай

Боловсролын ерөнхий хуулийн 3.1.23; 37.2.2-р зүйл, Дээд боловсролын тухай хуулийн 32.4-р зүйл, Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 3.2.6, 7.3 дахь заалтууд, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн Эндаументын сангийн журамд Эрдмийн зөвлөлийн гишүүдийн саналыг тусгаж, Удирдах зөвлөлийн хуралд танилцуулахыг дэмжсүгэй.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.НАМНАН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210003



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Тэнхимүүдийг шинэчлэн зохион байгуулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 11.1-р зүйл, "ШУТИС-ийн дүрэм"-ийн 3.8.3 дахь заалт, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 3.2.3, 5.3, 7.3 дахь заалтууд, Мэргэжлийн тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журмын 5.1 дэх заалт, Менежментийн сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн Эрдмийн түр зөвлөлийн санал, Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Сургалт, оюутны хөгжлийн дэд зөвлөлийн шийдвэр, Эрдмийн зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Менежментийн сургуулийн бүтцэд Бизнесийн удирдлагын тэнхим, Менежмент, стратегийн тэнхим, Эдийн засаг, санхүүгийн тэнхимийг тус тус шинэчлэн байгуулсугай.
2. ШУТИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн бүтцэд Нийгмийн ухааны тэнхим, Түүх, соёл, аялал жуулчлалын тэнхимийг тус тус шинэчлэн байгуулсугай.
3. Тэнхимүүдийн бүтэц, орон тоо, харьяалах сургалтын хөтөлбөрүүд, үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулж, холбогдох шийдвэрүүдийг тушаалаар баталгаажуулан хэрэгжүүлж ажиллахыг ШУТИС-ийн ректор Т.Намнан, Менежментийн сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч (Г.Баттүвшин), Нийгэм, хүмүүнлэгийн сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч (А.Энхбат) нарт үүрэг болгосугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Т.НАМНАН



ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210005



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

ШУТИС-ийн “Хүндэт профессор” цол олгох тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.6.2-р заалт, Эрдмийн зөвлөлийн дүрмийн 3.2.4; 3.2.5; 5.3; 7.3-р заалтууд, Эрдмийн ба хүндэт цол олгох журмын 4.1, заалт, Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэр, Эрдмийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд оролцсон гишүүдийн ил санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын мэргэжилтэн бэлтгэхэд оролцон, их сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийг шинээр нээх, багш, оюутны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, салбарын судалгаа шинжилгээний ажлыг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжсэн бодит хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Намиби улсын иргэн, Оюу-толгой ХХК-ийн Хүний нөөц, бүтэц зохион байгуулалтын хэлтсийн ерөнхий менежер, хатагтай Шаненганге МЕЛИССА Агнес-д ШУТИС-ийн “Хүндэт профессор” цол өргөмжилсүгэй.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Т.НАМНАН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЦОЛМОНБААТАР

367210008